

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран Шивээговь суманд 2018 оны 3 дугаар сарын 28-ны өдөр “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулаа.

Иргэдэд Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Газрын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулах, төрийн үйлчилгээг иргэдэд нэг дороос хүргэх боломжийг олгох, үйлчилгээний талаар иргэдийн санал хүсэлтийг авах зорилгоор ажиллалаа. “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т нийт 69 иргэнд үйлчиллээ. Үүнээс: 48 иргэнд гарын авлага, тараах материал, зөвлөгөө өгч, 5 иргэний өмчилсөн газарт хэмжилт хийн, 16 иргэн газар өмчилсөн материалаа сумын газрын даамалаас авч, Улсын бүртгэлийн хэлтсийн бүртгэгчид газар өмчлөх гэрчилгээгээ авахаар бүрдүүлж өглөө.




Аймгийн ГХБХБГ-аас газар өмчлөгч иргэдийн дэлгэрэнгүй судалгааг ирүүлэх албан бичгийн дагуу дэлгэрэнгүй судалгааг гаргаж байна.

➤ Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 2 байршлаас иргэдээс гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газрын өргөдлийг 2018.03.19-ний өдрийн 10:00 цагаас 2018.03.22-ний өдөр хүртэл авч дууссан. Нийт 250 иргэнд 26.5 га газар өмчлүүлэхээр хүсэлт ирүүлсэн.

- Зөрлөг хороололд /авто зам дагуу/-14 га-200 иргэнд
- Ургах хороололд-12.5 га -50 иргэнд

Иргэдийн өргөдлийн баримт бичгийн иж бүрдлийг шалган иргэдэд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулж байна.



Тайлан бичсэн: Газрын даамал Э.Баярмагнай